

Үйлчилгээний салбар: _____ Ажилтны нэр: _____ Огноо: _____

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Ургийн овог: Эцэг/эхийн нэр: Нэр:
 Регистрийн дугаар: Төрсөн огноо: Хүйс: Эр Эм
 Албан ёсны хаяг: Хот/Аймаг: Дүүрэг/Сум: Хороо/Баг:
 Хороолол/Гудамж: Байр: Тоот:

Хэрэглэгч би дээрх хаягийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг Улсын Бүртгэлийн Ерөнхий хуулийн 15.5.1-д заасны дагуу гаргуулан авахыг Скайтел ХХК-д үүгээр зөвшөөрч байна.

ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ХАЯГ Өөрийн эзэмшил Түрээс

Хот/Аймаг: Дүүрэг/Сум: Хороо/Баг:
 Хотхон: Байр: Тоот:

ЯАРЛАЙ БОЛОН ШААРДЛАГАТАЙ ҮЕД ХОЛБОО БАРИХ.

Нэр: Утас: Таны хэн болох:
 Нэр: Утас: Таны хэн болох:

Яарлтай болон шаардлагатай үед дээрх хүмүүст мэдээлэл хүргүүлэхийг зөвшөөрч байна.

UP ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Гэрээний дугаар: Үүрэн холбооны дугаар:

СОНГОСОН БАГЦ: TP 39500 багц Монголдоо 10000 Монголдоо 30000
 Гуравласан үйлчилгээ TP 49500 багц Үүрэн холбооны дугаар Монголдоо 20000 Монголдоо 40000

*Сүүр хураамжид өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс ороогүй болно.

UP ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ:
 40000 багц 50000 багц 60000 багц 70000 багц Дагалдах нэмэлт үйлчилгээ: SKY GO

НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

ТВ салаалалт Нийт үнэ ₮ Телевизийн тоо

ТӨЛБӨР ТӨЛӨХТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

Миний бие Скайтел ХХК-ийн UP үйлчилгээний гэрээний нөхцөлтэй бүрэн танилцаж зөвшөөрсөн, хувийн мэдээллээ үнэн зөв мэдүүлсэн бөгөөд өөрийн талаарх мэдээллийг цуглуулах, ашиглах, бусадтай солилцох эрхийг үйлчилгээ үзүүлэх талд олгосон болохоо баталгаажуулан гарын үсэг зурсан болно.

Үйлчилгээ авсан огноо: _____ Хэрэглэгчийн гарын үсэг: _____

Энэхүү УР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ /цаашид “Гэрээ” гэх/ нь Скайтел үүрэн холбооны БҮГ-ХҮА 2019/01, Скаймедиа БҮГ-ХҮА 2019/12-V10 тоот гэрээний нэмэлт гэрээ бөгөөд Нэг талаас: 2576376 тоот регистрийн дугаартай, 9011269026 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээтэй Монгол Улсын хуулийн этгээд болох СКАЙТЕЛ ХХК /цаашид “Үйлчилгээ үзүүлэгч” гэх/, Нөгөө талаас: Монгол Улсын Иргэн РД: _____, овогтой _____ /цаашид “Хэрэглэгч” гэх/ хамтад нь “Талууд” гэх /нар дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулах.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчид Ай Пи телевиз, Суурин интернет, Call үйлчилгээ, Үүрэн телефоны дараа төлбөрт дугаарын үйлчилгээ бүхий үйлчилгээ /цаашид “Үйлчилгээ” гэх/-г үзүүлэх, Хэрэглэгч нь гэрээнд заасны дагуу зохих төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү гэрээний өргөдлийн маягт болон УР үйлчилгээний нөхцөлийг энэхүү гэрээтэй хамт хэрэглэх ба эдгээр нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.3 УР үйлчилгээний гэрээ цуцлагдсан тохиолдолд Үүрэн телефоны дараа төлбөрт үйлчилгээний гэрээ болон Скаймедиа үйлчилгээний үндсэн гэрээнүүд мөрдөгдөнө.
- 1.4 Хэрэглэгч аливаа үйлчилгээг авахаар салбарт биелчлэн ирэх боломжгүй тохиолдолд нотариатаар баталгаажуулсан итгэмжлэлийг үндэслэн зөвхөн итгэмжлэлд заасан үйлчилгээг итгэмжлэгдсэн төлөөлөгчид үзүүлнэ.
- 1.5 Гэрээний өргөдлийн маягт болон УР үйлчилгээний нөхцөлийг, мэдээллийн эзний зөвшөөрлийн хуудсыг Гэрээтэй хамт хэрэглэх ба эдгээр нь Гэрээний салшгүй хэсэг байна. Хэрэв дээрх баримт бичиг хоорондоо зөрчилдвөл Гэрээг удирдлага болгоно.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Энэхүү гэрээ нь Хэрэглэгч УР үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч, Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж гэрээ цуцлагдах хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

ГУРАВ. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**3.1 Хэрэглэгч нь дараах эрхтэй**

- 3.1.1 Хэрэглэгч УР үйлчилгээний талаарх мэдээ, мэдээлэл, материалаар хангагдах эрхтэй.
- 3.1.2 Хэрэглэгч УР үйлчилгээний нөхцөлд заасны дагуу захиалгат үйлчилгээ авах эрхтэй.
- 3.1.3 Хэрэглэгч үйлчилгээний гэрээ байгуулахад өөрийн биеэр цахим үнэмлэхний хамт ирнэ. Хэрэглэгч өөрийн биеэр ирэх боломжгүй бол нотариатаар баталгаажуулсан итгэмжлэлийг үндэслэн зөвхөн итгэмжлэлд заасан үйлчилгээг итгэмжлэгдсэн төлөөлөгчид үзүүлэх эрхтэй.
- 3.1.4 Хэрэглэгч нь Үйлчилгээ үзүүлэгчээс олгож буй үйлчилгээ, хөнгөлөлт, урамшуулал болон үнэ тарифын талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомж, Үйлчилгээ үзүүлэгчийн дүрэм, журам, үйлчилгээний нөхцөлийн хүрээнд авах эрхтэй.
- 3.1.5 Үйлчилгээний талаар санал, гомдол гаргах, талархал илэрхийлэх эрхтэй.
- 3.2 Хэрэглэгч нь дараах үүрэгтэй**
 - 3.2.1 Хэрэглэгч нь өргөдлийн маягтыг үнэн зөв бөглөх үүрэгтэй.
 - 3.2.2 Хэрэглэгч нь өргөдлийн маягтын мэдээлэлд өөрчлөлт орвол ажлын 5 хоногт багтаан Үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх үүрэгтэй.
 - 3.2.3 Үйлчилгээ үзүүлэгчээс олгож буй үйлчилгээг энэхүү Гэрээ болон УР үйлчилгээний нөхцөлд заасны дагуу зүй зохистой ашиглах үүрэг хүлээнэ.
 - 3.2.4 Өмнөх сард ашигласан үйлчилгээний төлбөрөө Скаймедиа үйлчилгээний нөхцөлийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтаар заасан хугацаанд бүрэн төлөх үүрэгтэй.
 - 3.2.5 Хэрэглэгч нь баталгаат и-мэйл хаяг болон гар утсан дахь мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаагүйн улмаас үүдэн гарах аливаа хохирол үр дагаврыг Хэрэглэгч бүрэн хариуцна.
 - 3.2.6 Хэрэглэгч үйлчилгээний төлбөрийг төлөхөөс өмнө тооцооны үнэн зөвийг нягтлан шалгах үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлэгчид тохиолдолд тухайн төлбөртэй холбоотой аливаа гомдлыг Үйлчилгээ үзүүлэгч хүлээж авахгүй.
 - 3.2.7 Хэрэглэгч захиалгат үйлчилгээ авах тохиолдолд Скаймедиа үйлчилгээний нөхцөлд тухайлан заасан шаардлагыг хангасан байх үүрэгтэй.
 - 3.2.8 Хэрэглэгч үйлчилгээг гуравдагч этгээдэд дамлан борлуулах, хууль бусаар ашиглахгүй байх үүрэгтэй.
 - 3.2.9 Хэрэглэгч нь үйлчилгээг зүй зохистой бусаар /бусад хэрэглэгчийг залхаах, дарамтлах, гутаан доромжлох, өөр бусад байдлаар бусдын амгалан байдлыг алдагдуулах, сүлжээний хэвийн үйл ажиллагааг саатуулах, хүчдрэл учруулах зэргээр/ ашиглахгүй байх үүрэгтэй.
 - 3.2.10 Хэрэглэгч Үйлчилгээ үзүүлэгчээс олгосон нууц код /Sid код/, Wi-Fi код, үйлчилгээтэй холбоотой бусад нууц үг, нууц дугаарыг бусдад мэдэгдэж болохгүй. Хэрэв бусдад мэдэгдсэн, мэдэгдсэн байж болзошгүй бол Үйлчилгээ үзүүлэгчид нэн даруй хандаж нууц үг, нууц дугаарыг солих, үйлчилгээг хаалгах хүртэл арга хэмжээг авахуулах үүрэгтэй.
 - 3.2.11 Хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалан үйлчилгээний төлбөр өндөр гарах, үйлчилгээ доголдох, тасалдах гэх мэт аливаа асуудал, эрсдэл үүсэх тохиолдолд Хэрэглэгч өөрөө бие даан хариуцах ба Үйлчилгээ үзүүлэгч ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.
 - 3.2.12 УР үйлчилгээг 36 сарын хугацаанд тасралтгүй ашиглах ба скаймедиа үйлчилгээний түр салгалт болон үүрэн холбооны дугаарыг хадгалах үйлчилгээг авахгүй байх үүрэгтэй.
 - 3.2.13 Энэхүү гэрээний 4.1.5-д заасан Үйлчилгээ үзүүлэгчийн мэдэгдэлтэй тухай бүр танилцах үүрэгтэй.
 - 3.2.14 Хэрэглэгч нь үндсэн багцын сарын суурь хураамжийг төлөх үүрэгтэй.

ДӨРӨВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**4.1 Үйлчилгээ үзүүлэгч нь дараах эрхтэй**

- 4.1.1 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн үйлчилгээний төлбөрийг УР үйлчилгээний нөхцөлд зааснаар тооцож, мөн нөхцөлд тухайлан заасан өдөр нэхэмжлэх эрхтэй.
- 4.1.2 Үйлчилгээ үзүүлэгч нь зах зээлийн нөхцөл байдал, төрийн байгууллагын шийдвэр

болон хэрэглэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах шаардлагын улмаас УР үйлчилгээний нөхцөл, үнэ тариф болон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй ба энэ тохиолдолд Хэрэглэгчид ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө мессежээр эсхүл үйлчилгээний салбар болон Skytel.mn веб хуудсын аль нэгээр мэдэгдэх ба шаардлагатай тохиолдолд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдэгдэнэ.

- 4.1.3 Хэрэглэгч нь ийнхүү мэдэгдсэнээс хойш өөрчлөгдсөн нөхцөлийг хүлээн зөвшөөрөх эсэхээ ажлын 10 хоногийн дотор Үйлчилгээ үзүүлэгчид хариу мэдэгдээгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчийн саналыг буюу нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцох ба УР үйлчилгээний нөхцөл, үнэ тариф, гэрээний нэмэлт, өөрчлөлттэй танилцаагүй буюу мэдээгүй нь төлбөр төлөх үүрэг болон бусад үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
 - 4.1.4 Үндсэн багцын үйлчилгээний үнэ тарифыг тогтоох эрхтэй.
 - 4.1.5 Үйлчилгээ үзүүлэгч нь дараах үндэслэлээр Хэрэглэгчид урьдчилан сануулалгүйгээр үйлчилгээний эрхийг хаах эрхтэй. Үүнд:
 - 4.1.5.1 Өргөдлийн маягтын мэдээллийг санаатайгаар худал мэдүүлсэн, эсхүл 3.2.2-т заасан үүргээ биелүүлээгүй бол;
 - 4.1.5.2 Хэрэглэгч гэрээний хаяг дээрээ оршин суудаггүй болох нь тогтоогдсон бол;
 - 4.1.5.3 Үйлчилгээг зүй зохистой бусаар ашигласан тохиолдолд;
 - 4.1.5.4 Үйлчилгээ үзүүлэгчийн бусад үйлчилгээнд төлбөрийн маргаантай тохиолдлууд хамаарах;
 - 4.1.6 Хэрэглэгч үйлчилгээний нөхцөлд зааснаар үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд төлбөр төлөх хүртэлх хугацаанд үйлчилгээнд хязгаарлалт хийх эрхтэй.
 - 4.1.7 Хэрэглэгч үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд өр авлага барагдуулах зорилгоор Зээлийн мэдээллийн тухай хууль болон Төв Банк /Монгол банк/-тай байгуулсан гэрээний дагуу зээлийн мэдээллийн санд зээлийн ангиллыг бүртгүүлэх, мөн түүнчлэн хууль тогтоомжид заасны дагуу бусад арга хэмжээг авах эрхтэй.
 - 4.1.8 Хэрэглэгч Үйлчилгээ үзүүлэгчээс авсан аливаа үйлчилгээний төлбөрийг тогтоосон хугацаанд барагдуулаагүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчийн үйлчилгээний төлбөр болон төлбөр барагдуулахтай холбогдон гарсан зардлыг/ нотариатын үйлчилгээний хөлс, зардал, улсын тэмдэгтийн хураамж, баримт бичиг хуулбарласан зардал гэх мэт /хамтад нь нэхэмжлэх эрхтэй.
 - 4.1.9 Хэрэглэгч дахин шинэ үйлчилгээ авах хүсэлт гаргасан тохиолдолд өмнө байгуулсан гэрээтэй холбоотой амар нэгэн төлбөр тооцоотой асуудал үүссэн бол дахин гэрээ байгуулахаас татгалзах эрхтэй.
- 4.2 Үйлчилгээ үзүүлэгч нь дараах үүрэгтэй**
- 4.2.1 Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчид үйлчилгээг өөрийн техникийн боломж болон хүчин чадлын хүрээнд чанарын өндөр төвшинд үзүүлэх үүрэгтэй.
 - 4.2.2 Үйлчилгээ үзүүлэгч нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20.5.3-т заасны дагуу хэрэглэгчийн төлбөрөөс өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс тооцож, Монголын телевизүүдийн холбоонд шилжүүлэх үүрэгтэй.
 - 4.2.3 Аливаа гэмтэл, саатлыг шийдвэрлэхдээ тухайн гэмтэл саатлын төрөл, засварлах хугацаа зэргээс хамаарч 48 цаг болон түүнээс доош, боломжтой хугацаанд хүрдэн шуурхай үйлдвэрлэх хэвийн ажиллагаанд оруулах үүрэгтэй.
 - 4.2.4 Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчид үйлчилгээг өөрийн техникийн боломж болон хүчин чадлын хүрээнд чанарын өндөр төвшинд үзүүлнэ. Үйлчилгээ үзүүлэгчийн Хэрэглэгчид хүргэж буй үйлчилгээнд ачаалал ихтэй үеэр доголдох, саатал гарч болох бөгөөд энэ тухай Хэрэглэгчид урьдчилан сануулах үүрэгтэй.
 - 4.2.5 Үйлчилгээ үзүүлэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан үйлчилгээ тасалдсан тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох инженерийн дүгнэлтийг үндэслэн тасалдсан хугацааны төлбөрийг Хэрэглэгчийн тухайн сарын үйлчилгээний төлбөрөөс хасаж тооцох эсхүл хөнгөлөлт, урамшууллыг олгох үүрэгтэй.
 - 4.2.6 Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчийн үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэхийг УР үйлчилгээний нөхцөлд заасан өдөр и-мэйл хаяг, утасны дугаар эсхүл цахим салбар /IPTV/-ын аль нэгээр Хэрэглэгчид мэдэгдэх үүрэгтэй.
 - 4.2.7 Үйлчилгээтэй холбоотой хэрэглээний дэлгэрэнгүй мэдээллийг Хэрэглэгч өөрийн биеэр цахим үнэмлэхний хамт үйлчилгээний салбарт ирсэн тохиолдолд гаргаж өгөх үүрэгтэй.
 - 4.2.8 Хэрэглэгчийн мэдээллийн нууцыг чанд хадгалах үүрэгтэй.

ТАВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 5.1 Хэрэглэгч нь үйлчилгээний эрхээ Үйлчилгээ үзүүлэгчид албан ёсоор хандан гэрээний үндсэн дээр шилжүүлэхээс бусад байдлаар дур мэдэн гуравдагч этгээдэд шилжүүлсэн бол үүнээс үүдэн гарах хохирлыг гаргах бүрэн хариуцна. Нэг төхөөрөмжид ногдох хэрэглэгчийн тооноос хамаарч ачаалал үүсэж болох бөгөөд үүнээс үүдэн гарах асуудалд Үйлчилгээ үзүүлэгч хариуцлага хүлээхгүй.
- 5.2 Хэрэглэгч үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, төлбөрийн үлдэгдэлтэй бөгөөд өргөдлийн маягтад заасан хаягтаа байхгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчийн үйлчилгээний төлбөр төлөх үүргийн талаар болон өр авлага барагдуулах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах, Хэрэглэгчийг эрэн сурвалжлах зорилгоор гуравдагч этгээдэд Хэрэглэгчийн талаарх болон гэрээний тухай мэдээллийг өгөх, шалгуулах, төлбөр төлөхийг шаардах эрхийг Хэрэглэгчийн зөвшөөрөлгүйгээр хэрэгжүүлнэ.
- 5.4 Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний өргөдлийн маягтад өгөгдсөн Хэрэглэгчийн мэдээлэл болон үйлчилгээний гэрээ, хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалтыг өөрийн нууцад хамааруулан хадгалах бөгөөд дараах тохиолдлуудад гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхтэй. Үүнд:
 - 5.4.1 Хэрэглэгч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүссэн авлагыг барагдуулах зорилгоор;
 - 5.4.2 Хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагын шаардсанаар;
 - 5.5 Хэрэглэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн нууцад хамаарах мэдээллийг хууль бусаар олж авах аливаа үйлдэл хийсэн, олж авсан, олж авсан мэдээллийг хувийн болон бусад зорилгоор ашигласан, хэрэглэсэн, бусдад дамжуулсан, задруулсан бол энэхүү үйлдлийн улмаас учирсан эсхүл учирч болох аливаа хохирлыг бүрэн хариуцахын зэрэгцээ энэхүү гэрээ болон хуульд заасан бусад хариуцлага хүлээнэ. “Скаймедиа корпораци” ХХК-тай гэрээ байгуулсан хэрэглэгчийн бүртгэлтэй гар утасны дугаарт холбогдох, мессеж илгээх болон IPTV-цахим салбар, онлайн сувгууд (Скайтел аппликэйшн, веб хуудас, фэйсбүүк мессенжер, цахим хаяг)-аар
- 5.6

хэрэглэгчид багц өөрчлөх, гэрээ шинэчлэх үйлчилгээг санал болгож, хэрэглэгч үйлчилгээний нөхцөлийг хүлээн авахгүй тухай хариу мэдэгдлийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй тохиолдолд төлбөр, үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрөн хэлцэл хийсэнд тооцно.

- 5.7 “Скаймедиа корпораци” ХХК-тай гэрээ байгуулсан хэрэглэгчийн бүртгэлтэй утасны дугаарт илгээгдсэн баталгаажуулах код бүхий мессеж болон онлайн сувгийн бүртгэл зэрэг нь хэлцэл хийснийг нотлох баталгаа болно.

ЗУРГАА. ТӨЛБӨР ТООЦОО

- 6.1 Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчийн үйлчилгээний төлбөрийг UP үйлчилгээний нөхцөлд зааснаар тооцож, мөн нөхцөлд тухайлан заасан өдөр Хэрэглэгчээс нэхэмжилнэ.
- 6.2 Төлбөрийн нэхэмжлэх нь тухайн сарын суурь хураамж, үндсэн багцын сарын суурь хураамж, захиалгат үйлчилгээний төлбөр, бусад Хэрэглэгчид холбогдох төлбөр, сарын хэрэглээний дүнгээс зохих хөнгөлөлтийг хасаж тооцсоны дараах дүн, төлбөрийн үлдэгдэл, НӨАТ зэргээс бүрдэнэ.
- 6.3 Хэрэглэгч UP үйлчилгээний гэрээг цуцлах тохиолдолд цуцалсан сарын төлбөр биллинг циклээр тооцогдож, өмнөх сарын төлбөрийн үлдэгдэл, төхөөрөмжийн үлдэгдэл төлбөр, бусад холбогдох төлбөрийг бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 6.4 Гэрээний 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу үйлчилгээний төлбөр нэхэмжлээгүй нь Хэрэглэгчийг төлбөр төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 6.5 Үйлчилгээ үзүүлэгч нь төлөгдөөгүй төлбөрийг барагдуулахтай холбогдон гарсан нэмэлт зардлыг Хэрэглэгчээс нэхэмжлэх эрхтэй.
- 6.6 Хэрэглэгч нь Үйлчилгээ үзүүлэгчээс авсан аливаа үйлчилгээний төлбөрийг тогтоосон хугацаанд бүрэн барагдуулаагүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь Хэрэглэгчийн бусад үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэх дээр нэмж нэхэмжлэх ба үйлчилгээг хязгаарлах эрхтэй.
- 6.7 Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0,5% алданги тооцож нэхэмжлэх эрхтэй.

ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1 Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш Талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаанаар тухайлбал гал түймэр, үер, хур тунадас болон шороон шүүрга, газар хөдлөлт, аянга цахилгаан, галт уулын болон бусад тэсрэлт, дэлбэрэлт, цаг агаарын хэт халалт ба хүйтрэлт эсхүл төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээрийн дэглэм, гоц халдварт өвчин, ажил хаялт, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, зэвсэгт мөргөлдөөн, дайн /зарлагдсан болон зарлагдаагүй/, халдлага, түлш, эрчим хүчний хязгаарлалт, сүлжээний хэт ачаалал, доголдол, тасалдал зэрэг гэнэтийн буюу давагдашгүй шинжтэй нөхцөл байдлын улмаас Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлүүдийн улмаас үүдсэн нөхцөл байдал 30 хоногоос дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд Талууд гэрээг цуцлах талаар саналаа албан ёсоор бичгээр гаргах эрхтэй.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1 Энэхүү гэрээний улмаас үүсэх маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тийнхүү шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлэнэ.
- 8.2 Энэхүү гэрээг монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

БАГЦЫН ТӨРӨЛ	UP40	UP50	UP60	UP70
Сарын суурь хураамж*	40000₮	50000₮	60000₮	70000₮
Сэлэнгэ аймаг	43000₮	53000₮	63000₮	73000₮
Үндсэн багцын үнэ тариф /23 суваг/	2500₮	2500₮	2500₮	2500₮
Телевиз салаалалтын сарын суурь хураамж	9900₮	9900₮	9900₮	9900₮

Үйлчилгээ үзүүлэгчийг төлөөлж:

Хэрэглэгчийг төлөөлж:

Үйлчилгээний салбар

Үйлчилгээний ажилтан

Овог, Нэр

Гарын үсэг

НЭГ. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

- 1.1 Энэхүү UP үйлчилгээний нөхцөлд дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
- 1.1.1 “Хэрэглэгч” гэж үйлчилгээ үзүүлэгчтэй үйлчилгээний гэрээ байгуулж, үйлчилгээний төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх үүрэг хүлээсэн хувь хүнийг;
- 1.1.2 “Холболтын хураамж” гэж Гэрээ байгуулах, үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэхтэй холбоотой үүссэн үйлчилгээний эргэн төлөгдөхгүй нэг удаагийн төлбөрийг;
- 1.1.3 “Сарын суурь хураамж” гэж Хэрэглэгч нь үйлчилгээ үзүүлэгчийн сүлжээ ашигласнаар сар бүр тогтмол төлөх төлбөрийг;
- 1.1.4 “Нэмэлт үйлчилгээ” гэж сонгосон багцад дагалдах хэрэглээнээс бусад нэмэлтээр үзүүлж буй нэмэлт сувгийн багц, нөхөж үзэх, ухраах, зогсоох, дахин эхлүүлэх, бичлэг хийх, видео сангаас кино түрээслэн үзэх гэх мэт хэрэглэгчийн ашиглаж байгаа яриа, мессеж, дата хэрэглээнээс бусад нэмэлтээр үзүүлж буй үйлчилгээ;
- 1.1.5 “Төлбөрийн нэхэмжлэл” гэж UP үйлчилгээнд бодогдсон, тухайн сарын хэрэглээний төлбөр, сарын суурь хураамж, үндсэн багцын суурь хураамж, бусад холбогдох төлбөр, хөнгөлөлт болон НӨАТ зэргийн нийлбэр дүнг;
- 1.1.6 “Эзэмших эрх шилжүүлэх” гэж Хэрэглэгч өөрийн нэр дээр эзэмшиж буй UP үйлчилгээг бусдын нэр дээр шилжүүлэх үйлчилгээ;
- 1.1.7 “Биллинг цикл” гэж Сарын эхний өдрөөс сүүлийн өдөр дуустал хугацааг;
- 1.1.8 “Хурууны хээ үншигч” гэж Төрийн мэдээлэл солилцооны ХҮР системийн мэдээлэлд үндэслэн хэрэглэгчийн хурууны хээг таньж, улсын бүртгэл дахь мэдээллийг хэрэглэгчийн мэдээллийн санд татан авах зориулалт бүхий төхөөрөмж;
- 1.1.9 “Үйлчилгээ хязгаарлах” гэж Гуравласан үйлчилгээний хаалт болон мобайл дугаарын орох, гарах яриа, мессеж, дата болон нэмэлт үйлчилгээ, тухайн багцын үйлчилгээний эрхийг хязгаарлахыг;
- 1.1.10 “UP” гэж Үүрэн холбооны дараа төлбөрт үйлчилгээ, АйПи Телевиз (IPTV), интернэт, Cally үйлчилгээ бүхий үйлчилгээг хамтад нь ойлгоно;
- 1.1.11 “Үүрэн холбооны дугаар” гэж Скаймедиа үйлчилгээтэй нэгтгэн ашиглаж буй Скайтийн үүрэн холбооны дугаар;
- 1.1.12 “Ай Пи Телевиз (IPTV)” гэж интернэт протокол дээр суурилсан телевизийн үйлчилгээ;
- 1.1.13 “Cally үйлчилгээ” гэж интернэт протокол дээр суурилсан харилцаа холбооны үйлчилгээ;
- 1.1.14 “Олон улсын яриа үйлчилгээ” гэж олон улсын яриа үйлчилгээний барьцаа байршуулсан хэрэглэгч 002 гарцыг ашиглан гадаад улс руу дуудлага хийх, мессеж илгээх үйлчилгээ;
- 1.1.15 “SkyGo” гэж компьютер, таблет, гар утас ашиглан интернэт орчинд үзэх боломжтой IPTV үйлчилгээ;
- 1.1.16 “Олон нийтийн телевиз” гэж Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд заасан зөвхөн олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, ашгийн төлөө бус, телевизийн үйлчилгээ;
- 1.1.17 “Өргөн нэвтрүүлгийн телевиз” гэж Олон талт хөтөлбөртэй, олон суваг дамжуулах үйлчилгээний сүлжээгээр заавал дамжих арилжааны телевизийн үйлчилгээ;
- 1.1.18 “Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлс” гэж Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20.5.3-т заасны дагуу үндсэн багцын үйлчилгээний төлбөрөөс тооцож, Монголын телевизүүдийн холбоонд шилжүүлэх төлбөрийг;
- 1.1.19 “Үндсэн багц” гэж Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4.1.19, 26.5-д заасны дагуу олон нийтийн телевиз, түүний нэмэлт суваг болон өргөн нэвтрүүлгийн телевизийн сувгуудыг багтаасан үйлчилгээ;
- 1.1.20 “Үндсэн багцын суурь хураамж” гэж Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26.6, 31.2.2-т заасны дагуу Үйлчилгээ үзүүлэгчийн тогтоосон үйлчилгээний үнэ тарифыг;
- 1.1.21 “Монголын телевизүүдийн холбоо” гэж Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлсийг төвлөрүүлж, гишүүдэд хуваарилах чиг үүрэг бүхий өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн заавал гишүүнчлэлтэй, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг;
- 1.1.22 “Тоног төхөөрөмж” гэж Үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж буй WiFi цацагчтай төхөөрөмж болон SETTOP BOX төхөөрөмжийг;
- 1.1.23 “Тоног төхөөрөмжийн дагалдах хэрэгсэл” гэж Удирдлага, тэжээлийн залгуур, HDMI, AV, LAN кабелиудыг;
- 1.1.24 “Мэдээллийн эзний зөвшөөрлийн хуудас” гэж “Скаймедиа корпораци” ХХК нь Хэрэглэгчид өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэхдээ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.4, 8.1, 8.2, 8.3, 8.4, 9.2.1, 18.1, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12.4-т тус тус заасны дагуу мэдээллийн эзэнд танилцуулж авсан зөвшөөрлийн нөхцөлийг;

ХОЁР. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

2.1 Шинэ хэрэглэгч болох

- 2.1.1 UP үйлчилгээ рүү шилжихэд Скаймедиа үйлчилгээ, Скайтийн үүрэн холбооны дугаарын гэрээ эзэмшигчийн нэр ижил байна.
- 2.1.2 Хэрэглэгчтэй дараах бичиг баримтыг үндэслэж гэрээ байгуулна. Үүнд:
- 2.1.2.1 Цахим үнэмлэх эсвэл хурууны хээ уншигчийн мэдээллийг үндэслэх;
- 2.1.2.2 Скаймедиа болон Скайтел үүрэн холбооны дугаарын гэрээг тус тус үндэслэх;

2.2 Үндсэн үйлчилгээний нөхцөл

Багц	Сарын суурь хураамж	Хөнгөлөлттэй үнэ
UP	49,500₮	40,000₮
UP	59,500₮	50,000₮
UP	79,500₮	60,000₮
UP	89,500₮	70,000₮
Сэлэнгэ UP	52,500₮	43,000₮
Сэлэнгэ UP	62,500₮	53,000₮
Сэлэнгэ UP	82,500₮	63,000₮
Сэлэнгэ UP	92,500₮	73,000₮

- 2.2 Скаймедиа үйлчилгээтэй нэгтгэн ашиглаж буй үүрэн холбооны дугаарыг Скаймедиа гэрээний бүртгэлтэй дугаараар заавал бүртгэнэ.
- 2.4 UP үйлчилгээний хөнгөлөлт Монголдоо үйлчилгээний суурь хураамжаас хасагдана.
- 2.5 Скаймедиа үйлчилгээнд авч байсан урамшууллууд UP үйлчилгээ рүү шилжих үед зогсоно.
- 2.6 **Сарын суурь хураамж**
- 2.6.1 Скаймедиа үйлчилгээний шинэ хэрэглэгч бол үйлчилгээний эхний сарын суурь хураамж өдрийн алхмаар тооцогдоно.
- 2.6.2 Сарын дундуур UP үйлчилгээ рүү шилжсэн тохиолдолд шилжсэн багцын сарын суурь хураамжаар тухайн сарын нэхэмжлэх бодогдоно.
- 2.6.3 Сарын дундуур багц хооронд шилжсэн тохиолдолд шилжсэн багцын сарын суурь хураамжаар тухайн сарын нэхэмжлэх бодогдоно.
- 2.6.4 Үүрэн холбооны дугаар нь шинэ хэрэглэгч бол Үүрэн холбооны дугаарын эхний сарын суурь хураамж доорх нөхцөлөөр бодогдоно.

Шинэ хэрэглэгч болсон хугацаа	Сарын суурь хураамж
1-10 хоног	100%
11-20 хоног	50%
21-30 хоног	30%

- 2.6.5 Сарын суурь хураамжийг биллинг циклээр тооцно.
- 2.6.6 Үйлчилгээний төлбөрөө хугацаандаа төлөөгүйгээс үйлчилгээ хязгаарлагдсан болон хязгаарлагдсаны улмаас үйлчилгээ нээсэн сарын суурь хураамжийг биллинг циклээр буюу бүтнээр тооцно.
- 2.6.7 Хэрэглэгч дараах нөхцөлүүдэд сарын суурь хураамжаас чөлөөлөгдөнө. Үүнд:
- 2.6.7.1 Хэрэглэгч гэрээгээ түр хаалгасан тохиолдолд;
- 2.6.7.2 Гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэгчийн эрхийн дагуу хэрэглэгчийн үйлчилгээг бүхэлд нь хаасан тохиолдолд;
- 2.7 **Үйлчилгээний хугацаа**
- 2.7.1 UP үйлчилгээ рүү шилжсэн хэрэглэгчийн гэрээний хугацаа TP үйлчилгээний гэрээ хийсэн хугацаанаас үргэлжилж тооцогдоно.
- 2.8 **Багцын хэрэглээний эрх**
- 2.8.1 UP үйлчилгээний багцад дагалдах эрхүүд:

БАГЦЫН ТӨРӨЛ	UP40	UP50	UP60	UP70
Сүвгийн тоо	120+ суваг	120+ суваг	120+ суваг	120+ суваг
Интернэт хурд	30 Mbps	30 Mbps	60 Mbps	60 Mbps
Cally ярианы эрх*	Скайтел болон Cally сүлжээнд үнэгүй, Бусад сүлжээнд 30₮			
	Бусад сүлжээнд 15,000₮/500мин	Бусад сүлжээнд 15,000₮/500мин	Бусад сүлжээнд 15,000₮/500мин	Бусад сүлжээнд 15,000₮/500мин
Контент үзэх эрх	2 контент (БХТ контент орохгүй)	2 контент (БХТ контент орохгүй)	10 контент (БХТ контент орохгүй)	10 контент (БХТ контент орохгүй)
Skygo нэмэлт эрх	GO Basic багц	GO Basic багц	GO Basic багц	GO Basic багц
Монголдоо	Монголдоо 10,000₮	Монголдоо 20,000₮	Монголдоо 30,000₮	Монголдоо 40,000₮
НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ				
Нөхөж үзэх, ухраах, зогсоох	(+)	(+)	(+)	(+)
Гэр бүлийн сувгийн багц	(+)	(+)	(+)	(+)
HBO сувгийн багц	(+)	(+)	(+)	(+)
Кино галерей /SVOD/	(+)	(+)	(+)	(+)

ГУРАВ. ЗАХИАЛГАТ ҮЙЛЧИЛГЭЭ

3.1 Багц хооронд шилжилт

- 3.1.1 Багц хооронд шилжиж байгаа тохиолдолд скаймедиа үйлчилгээ гэрээ хийсэн өдрөөс эхлэн шилжих ба үүрэн холбооны дугаарын багц дараа сарын 1-ний өдөр шилжинэ.
- 3.1.2 Багц хооронд шилжихэд үүрэн холбооны дугаарын багц нь скаймедиа үйлчилгээний шилжих багцаас хамаарч өөрчлөгдөнө.
- 3.1.3 UP үйлчилгээ рүү шилжсэн тохиолдолд тухайн сарын скаймедиа үйлчилгээний төлбөр шинэ багцаар, үүрэн холбооны дугаар хуучин багцын төлбөрөөр тус тус бодогдоно.
- 3.1.4 Хэрэглэгч Скаймедиа үйлчилгээ болон үүрэн холбооны дугаарын багцыг дангаар нь солих боломжгүй.
- 3.1.5 Хэрэглэгч гэрээний хугацаанд багц ахих боломжтой, багц буурах боломжгүй.
- 3.2 **Телевиз салаалах**
- 3.2.1 Хэрэглэгч телевиз салаалах үйлчилгээг 3 хүртэлх зурагтад ашиглах боломжтой. Салаалалт бүрийн тоогоор HD бокс төхөөрөмжийг Үйлчилгээ үзүүлэгчийн тухайн үеийн тогтоосон үнээр урьдчилгаа төлбөр төлж лизингээр авч болно.
- 3.2.2 Салаа төхөөрөмжийн лизингийн хугацаа 12 сар байна.
- 3.2.3 Салаа төхөөрөмж түр салгахад үнэ төлбөргүй байна.

3.3 Үйлчилгээ түр салгах, нээх

3.3.1 UP үйлчилгээний хэрэглэгч скаймедиа үйлчилгээг түр салгах болон үүрэн холбооны дугаарыг хаалгах, хадгалуулах боломжгүй.

3.4 Нэмэлт үйлчилгээ

3.4.1 Хэрэглэгч нэмэлт үйлчилгээг сарын хэдний өдрөөс үл хамааран мессеж, Скайтел веб сайт, IPTV цахим салбар, үйлчилгээний салбар, лавлах төвд хандан идэвхжүүлэх, цуцлах боломжтой.

3.4.2 Нэмэлт үйлчилгээний төлбөрийг 1 (нэг) сарын алхмаар тооцох бөгөөд сар хүрээгүй хэрэглээг 1 (нэг) бүтэн сараар тооцно.

ДӨРӨВ. ЭЗЭМШИХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ

4.1 Эзэмших эрх шилжүүлэх тохиолдолд эзэмших эрх шилжүүлэгч болон эзэмших эрх хүлээн авагч тус тус өөрийн биеэр үйлчилгээний салбарт хандах ба цахим үнэмлэх эсвэл хурууны хээ уншигчийн мэдээллээр эзэмших эрх шилжүүлнэ.

4.2 Эзэмших эрх шилжүүлэх тохиолдолд сар бүрийн 6-ны өдрөөс эхлэн шилжүүлэх бөгөөд нийт төлбөрийн үлдэгдлийг бүрэн барагдуулсан байна.

4.3 UP үйлчилгээний эзэмших эрхийг Скаймедиа үйлчилгээ, үүрэн холбооны үйлчилгээгээр салгаж шилжүүлэх боломжгүй байна.

4.4 Дараах хүндэтгэх шалтгаанаар эзэмших эрх шилжүүлэх боломжтой. Үүнд
4.4.1 Эзэмшигч нас барсан тохиолдолд эрх хүлээн авагч өөрийн биеэр эзэмшигчийн нас барсны гэрчилгээ, эзэмшигчийн гэр бүлийн гишүүн (гэр бүлийн гишүүн гэдгийг эзэмшигчийн эхнэр, нөхөр, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, насанд хүрсэн төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүүг ойлгоно) болохыг нотолсон лавлагааны хамт үйлчилгээний салбарт ирнэ.

4.4.2 Эзэмшигч гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа тохиолдолд эрх хүлээн авагч дараах аль нэг бичиг баримтын хамт үйлчилгээний салбарт ирнэ.

4.4.2.1 Тухайн улсад /гадаадад /оршин сууж буйг нотолсон баримт бичиг;

4.4.2.2 Гадаад паспортын хуулбар, визийн хуулбарын хамт;

4.4.2.3 Эзэмшигчийн цахим үнэмлэх;

4.4.2.4 Эзэмших эрхээ шилжүүлэхийг зөвшөөрсөн тухай баталгаат гарын үсэгтэй өргөдөл, хүсэлтийг баталгаажуулсан байх;

ТАВ. ТӨЛБӨР ТООЦОХ

5.1 Төлбөрийн нэхэмжлэх

5.1.1 Скаймедиа үйлчилгээ, Скайтелийн үүрэн холбооны дугаартай нэгдсэн нэг нэхэмжлэх гарна.

5.1.2 Хэрэглэгч төлбөрийн нэхэмжлэхийн дагуу төлбөрөө сар бүрийн 06-20-ны өдрийн дотор төлнө.

5.1.3 Төлбөрийн нэхэмжлэлийг сар бүрийн 06-ны өдөр гэрээн дээрх бүртгэлтэй дугаар болон UP үйлчилгээний үүрэн холбооны дугаарт мессежээр, бүртгэлтэй и-мэйл хаягаар, Скайтел аппликейшн, IPTV цахим салбараар мэдээлэл хүргэнэ.

5.1.4 Үйлчилгээ үзүүлэгч хэрэглэгчийн өргөдлийн маягт дахь хаяг, гар утасны дугаарт төлбөрийн нэхэмжлэх болон өөрчлөлт орсон үйлчилгээний талаарх мэдээллийг мэдэгдсэн нь хэрэглэгчийг төлбөр төлөхөөс чөлөөлөх, мэдээлэл хүлээн аваагчид тооцох үндэслэл болохгүй.

5.1.5 Скаймедиа үйлчилгээний Үндсэн багцын суурь хураамж нь Гуравласан үйлчилгээний сарын суурь хураамжийн хамт үйлчилгээний төлбөр дээр нэхэмжлэгдэх бөгөөд Үндсэн багцыг хасуулах болон цуцлах боломжгүй байна.

5.2 Хэрэглээний мэдээлэл

5.2.1 Хэрэглэгч сүүлийн 3 сарын хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалтыг авах боломжтой.

5.2.2 Хэрэглээний дэлгэрэнгүй А-4-ийн 2 хүүдаснаас хэтэрсэн нөхцөлд 2000₮ төлнө.

5.2.3 Cally үйлчилгээний хэрэглэгч өөрийн ярианы дэлгэрэнгүй жагсаалтыг www.cally.mn веб сайтаар өөрийн SIP кодыг ашиглан сүүлийн 6 сарын хугацаагаар харах боломжтой.

5.2.4 Хэрэглэгч Скайтел аппликейшн эсвэл ТВ-Цахим салбар ашиглан төлбөрийн мэдээлэл авах, бүртгэлтэй гар утасны дугаар, и-мэйл хаягийг шинэчлэх боломжтой.

5.3 Үйлчилгээний төлбөр төлөлт

5.3.1 Төлбөр төлөлт хийгдэх үед эхлээд Скаймедиа үйлчилгээний төлбөр төлөгдөж, дараа нь үүрэн холбооны дугаарын төлбөр төлөгдөнө.

5.3.2 Төлбөрийн илүү төлөлт нь дараа сарын Скаймедиа үйлчилгээний төлбөрөөс хасагдана.

5.3.3 Төлбөр төлөлт 5000 төгрөгөөс дээш дүнгээр дутуу хийгдвэл Скаймедиа, Скайтелийн үйлчилгээ нээгдэхгүй.

5.4 Үйлчилгээний төлбөр төлөх боломж

5.4.1 Хэрэглэгч хэрэглээний төлбөрийг сар бүрийн 20-ны дотор доорх сувгуудаас сонгон төлөх боломжтой. Үүнд:

5.4.1.1 Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний салбарт хандах;

5.4.1.2 Скайтел веб сайт, аппликейшн болон банкны бүх аппликейшн, киоск машин;

5.4.1.3 Скайдилерт хандах;

5.4.1.4 USSD банк;

5.4.1.5 Lend.mn;

5.4.1.6 Худалдаа хөгжлийн банк болон Хаан банкны АТМ-ээр;

5.4.1.7 Банкны автомат данс ашиглана;

ЗУРГАА. ҮЙЛЧИЛГЭЭ ХЯЗГААРЛАХ

6.1 Сар бүрийн 20-нд үйлчилгээний хязгаарлалт хийх ба төлбөр төлөөгүй тохиолдолд дараах хязгаарлалтыг хийнэ. Үүнд:

6.1.1 Телевизийн сувгийн тоо 5 хүртэл цөөлөх;

6.1.2 Интернет хурдыг Okbps болгох;

6.1.3 Мобайл дугаарын гарах ярианы эрх хаалттай, орох ярианы эрх нээлттэй байх;

6.1.4 Cally үйлчилгээний гарах ярианы эрх хаалттай, орох ярианы эрх нээлттэй байх;

6.2 Сарын сүүлийн өдөр төлбөр төлөөгүй бол төлбөр барагдуулах өдөр хүртэл үйлчилгээг бүрэн хязгаарлана.

6.3 Төрийн эрх бүхий байгууллага албан тушаалтнуудаас гаргасан нийтээр дагаж мөрдөх тушаал /шийдвэр, захирамж, хэм хэмжээ тогтоосон акт/-ын дагуу хэрэглэгчийн үйлчилгээг хязгаарлаж зогсоож болно.

ДОЛОО. ХЭРЭГЛЭГЧИЙН ХҮСЭЛТЭЭР UP ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ГАРГАХ

7.1 Хэрэглэгч өөрийн хүсэлтээр UP үйлчилгээнээс гарсан тохиолдолд харгалзах багцууд руу автоматаар шилжиж, үйлчилгээ тус бүрийн үндсэн гэрээг мөрдлөг болгоно.

7.2 Хэрэглэгч төлбөрийн үлдэгдлээ бүрэн барагдуулснаар UP үйлчилгээнээс гарна.

7.3 UP үйлчилгээнээс гарсан өдрөөс эхлэн UP үйлчилгээний гэрээ автоматаар хүчингүй болно.

7.4 UP үйлчилгээнээс гарсан сараас эхлэн үйлчилгээ тус бүрийн төлбөр үндсэн гэрээний нөхцөлийн дагуу тусдаа бодогдож нэхэмжлэгдэнэ.

7.5 UP үйлчилгээний гэрээ дараах тохиолдолд цуцлагдана. Үүнд:

7.5.1 Гэрээнд заасан аль нэг тал үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө талын санаачлагаар;

7.5.2 Хэрэглэгчийн эрх зүйн чадвар дуусгавар болсон;

7.5.3 Хуульд заасан бусад үндэслэлээр;

7.6 Хэрэглэгч UP үйлчилгээгээ дахин ашиглах бол үйлчилгээний салбарт хандаж бүртгэлээ хийлгэнэ.

НАЙМ. БУСАД

8.1 Энэхүү UP үйлчилгээний нөхцөлд шууд заагаагүй, тусгагдаагүй бусад үйлчилгээний нөхцөлийг тухайн үед Скайтел ХХК-ийн хэрэглэгчид үзүүлж буй үйлчилгээний нөхцөлөөр зохицуулагдах ба UP үйлчилгээний нөхцөлд Скайтел ХХК дангаараа өөрчлөлт оруулах эрхтэй.

8.2 UP үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт орох тохиолдолд Skytel.mn веб сайтад байршуулан мэдээлэл хүргэлт хийнэ.

Банк	Гүйлгээний утга	
ХХБ банк	499 120 987,	499 205 065
Хас банк	500 167 8218 ,	500 073 3393
Хаан банк	503 801 9105 ,	500 343 9787
Голомт банк	110 204 6354 ,	110 204 7493
Төрийн банк	106 000 002 84 ,	100 200 013 183